



ХЭНГИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 6/32

Хэрлэн сум

Буцалтгүй тусламж олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, аймгийн Засаг даргын Тамгын газрын “Дотоод журам”-ын 7 дугаар зүйлийн 7.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэлийн төлөөлөгч Э.Баянмөнхийн гаргасан өргөдлийн дагуу нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 1500000 (нэг сая таван зуун мянган) төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Буцалтгүй тусламжид шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын тэтгэмж, урамшууллын зардлаас санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн удирдлага, агентлаг хариуцсан мэргэжилтэн (С.Оюун-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР